

ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН ОРНООР 3 ДОЛОО ХОНОГ

Ц. Батбаяр*

1992 оны 4 дүгээр сарын 1—5.

Тайландын нийслэл Бангкок орохоор «Катэй Пасифик» авиакомпанийн нисэх онгоцонд сууж явахад Гонконгод хэвлэгддэг долоо хоног тутмын «эйшауик» сэтгүүлийн нэгэн дугаар анхаарал татав. Энэ дугаарт Афганистанаас эхлэн Вьетнам хүртэл 40 гаруй орны хөгжлийн үндсэн үзүүлэлтийг тоо баримтаар үзүүлжээ. Бидний очих ЗӨА-ийг газарзүйн хувьд эх газрын болон арлын гэсэн хоёр хэсэгт хувааж болно. Эхнийхэд Бурхны шашинтай Бирм, Тайланд, мөн Энэтхэг-Хятадын хойгийн орнууд багтана. Арлын хэсэг нь Малайн орнууд болох Индонез, Малайз, Бруней, Сингапур болон Филиппинээс бүрдэнэ. Сингапурын хүн амын дийлэнх нь хятадууд учраас Малайн тэнгис дэх бяцхан хятад аралтай ч зүйрлэх тал бий. Бурхны шашинт Тайландын вант улсын нийслэл Бангкок ЗӨА-ийн эх газрын хэсэгт стратегийн чухал байр эзэлдэг. 57 сая хүн амтай энэ орны нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүн 1605 ам. долларт хүрчээ. Энэ үзүүлэлт 3 сая хүн амтай Сингапурт хамгийн өндөр— 13600 ам. доллар, 18 сая хүн амтай Малайзад 2465 ам. доллар, 64 сая хүн амтай Филиппинд 725 ам. доллар, тэгвэл хамгийн олон 183 сая хүн амтай Индонезэд хамгийн бага— 605 ам. доллар байх жишээтэй. Харин эдийн засгийн хөгжлийн хурдцыг авч үзэх юм бол Малайз, Тайланд тэргүүлэх бөгөөд Сингапур, Индонез удаалан, Филиппин сүүл барьж явна.

Тайландын Хөгжлийн институтын орлогч захирал Ватчай Тайландын эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвийг өөдрөгөөр тодорхойлов. Цаашид эдийн засгийн өсөлтийг хэт өндөр бус, харин жилд 7-8 хувь байлгах бүрэн бололцоотой ажээ. 15 жилийн өмнөхтэй харьцуулбал экспортын зах зээлийг оновчтой тэлж чадсан байна. Эдүгээ Тайландын экспортын зах зээлийн 20 хувь АНУ-д, 20 хувь Европт, 16--18 хувь Японд ногдох болжээ. 1986—1989 онд Тайландын экспорт жилд 30 хувиар өсөж иржээ. Гэвч цаашдаа ийм хурдцаар өсөх боломжгүй. Учир нь Тайландад ажлын хөлс өндөр болж, мэргэжилтэй ажилчид улам өндөр хөлс олохоор гадаадад цагаачлах нь олширчээ. Ирээдүйд Тайланд хөдөлмөрийн багтаамж ихтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар Хятад, Индонезийн зүгээс тун шаргуу өрсөлдөөнтэй учирч болзошгүйг тайлбарлав. Тайландын томоохон Их сургуулийн нэг Чулалонгкорн Их сургуулийн улс төрийн факультетийн декан Сучит Тайландын хөгжлийн хоёр хүчин зүйлийг нэрлэв. Үүнд, Нэгд, хувийн сектор Тайландын хөгжлийн хөдөлгүүр болж өгсөн бөгөөд Засгийн газар хөндлөнгөөс нэг их оролцоогүй, хоёрт, Тайландад оршин суугч хятад гаралтай иргэдийг хавчин гадуурхах явдал хэзээ ч байгаагүй, тэдэнд бизнес эрхлэх бүрэн бололцоог тавьж өгсөн байна. Тайландын өөр нэг томоохон улсын Их сургууль Таммасаатын Их сургуулийн эдийн засгийн факультетийн декан, багш нартай уулзалт хийв. Тайландад 20 орчим улсын Их сургууль, мөн төдий тооны хувийн Их сургууль, багш нарыг бэлтгэх 32 коллеж, хөдөө аж ахуйн коллеж 20 орчим байдаг байна. Сургалтын төлбөр харьцангуй доогуур, нэг оюутан жилд дунджаар 10 мян. орчим бат (400 орчим ам. доллар) төлдөг. Эдийн

* Ц. Батбаяр — Дорно дахин, олон улс судлалын хүрээлэнгийн захирал, түүхийн ухааны дэд эрдэмтэн

засгийн факультет багш нараа Рокфеллерийн сангийн тусламжтай хөгжилтэй орнуудад илгээж өндөр төвшинд бэлтгэсэн байна. Тус факультетийн 70 орчим багшийн 40 нь гадаад, дотоодод докторын зэрэг хамгаалжээ. Тэд сүүлийн жилүүдэд Вьетнам, Кампучид мэргэжилтэн бэлтгэх талаар туслалцаа үзүүлж байгаа ажээ. Мөн Монголын зах зээлд шилжих явцыг ихэд сонирхож, мэргэжлийн туслалцаа үзүүлэх бололцоотойгоо илэрхийлж байв.

4 дүгээр сарын 6—9.

Бид Бангкокоос Манилыг зорин 4 дүгээр сарын 5-нд нисэх ёстой байсан боловч Манилын онгоцны буудлын онгоцны нислэгийг хянагч нарын ажил хаялтаас шалтгаалан Бангкокт дахин нэг хоног өнжиж, маргааш нь Манилд ирцгээв. Филиппиний ерөнхийлөгчийн сонгууль 5 дугаар сарын 11-нд болох, үүнд улс төрийн янз бүрийн намаас нэр дэвшигдсэн 8 хүн өрсөлдөж байлаа. Бидний уулзсан Филиппиний сэхээтнүүд 1986 онд түлхэгдэн унасан Маркосын дэглэмийг «дарангуйллын жилүүд» гэж тодорхойлж байв. Гэвч Корасан Акиногийн Засгийн газрын үйл ажиллагааг өндөр үнэлэх хүн бараг тааралдсангүй. Акиног түлхэн унагаах гэсэн байнгын оролдлого, улс төрийн тогтворгүй байдал, Филиппин дэх Америкийн цэргийн баазын талаарх маргаан, зэрэг нь Филиппиний эдийн засагт сөрөг нөлөө үзүүлсэн бололтой. Манил хотод цахилгаан тасрах нь ердийн үзэгдэл болсон тухай хотын оршин суугчид өгүүлж байв.

Филиппиний парламентын Төлөвлөлт, төсвийн газрын захирал Ромуло Неритэй уулазв. Уг газар Филиппиний Засгийн газраас парламентэд оруулж ирсэн жилийн төсөв дээр голчлон ажилладаг байна. Энэ 1992 оны улсын төсвийн алдагдал өнгөрсөн оныхоос 20 хувь өсөхөөр Засгийн газар төлөвлөснийг уг газар 10 хувь болгох саналыг өөрийн «босс» болох парламентын спикер Митрад оруулжээ. Мөн орон нутгийг төвөөс төвлөн удирдах явдлыг задлах чиглэлээр санал боловсруулж, 1991 оноос эхлэн энэ үйл явц хэрэгжиж эхэлсэн байна. Филиппиний орон нутгийн 13 бүсийн эрх мэдлийг тус тусын мужийн захир гаанд шилжүүлжээ. Филиппинд ажилгүйдэл нийт ажиллах чадвартай хүн амын 10 хувьд хүрч банья. Иймээс сүүлийн жилүүдэд гадаадад ажиллахаар явагсдын тоо эрс олширчээ. Сүүлд сонсвоос Ромуло Нери парламентын спикер Митрагийн шууд удирдлагад ажилладаг бөгөөд хэрвээ Митра 5 дугаар сарын сонгуульд ялбал Нери ерөнхийлөгчийн дэргэд ажиллахаар Засгийн газарт очиход гайхах явдалгүй ажээ.

Филиппиний Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын туслах Алан Ортизтэй уулзав. Түүний хэлснээр уг зөвлөл саявтар хоёр жилийн өмнө байгуулагдсан. Засгийн газрын гол гол сайд зөвлөлд ордог. Ноднин Персийн булангийн хямралын үеэр Зөвлөлийн ажиллагаа жигдэрч, улс орны аюулгүй байдлын асуудлаар ерөнхийлөгчид шууд илтгэл оруулдаг болсон байна. Тухайлбал, Персийн булангийн хямрал Филиппиний эдийн засагт хэрхэн нөлөөлөх, мөн гадаадад, ялангуяа арабын орнуудад гарч ажилладаг Филиппиний олон тооны ажилчдад яаж тусах зэрэг асуудал багтдаг байна.

4 дүгээр сарын 10—12.

Малайзын нийслэл Куала- Лумпурын нисэх онгоцны буудал дээр Монголоос яваа гэхэд паспортын хяналтынхан бага зэрэг сонирхон шалгаасан боловч гаалийнхан огт саатуулахгүй маш түргэн гаргалаа. Нисэх онгоцны буудлаас 30 орчим минут явж хотын төвд хүрдэг ажээ. Замын хажуугаар халуун орны нов ногоон модод ярайж, бүх юм нь эмх журамтай, цэвэр цэмцгэр. Зарим барилга дээр «2020» гэсэн тоо

байхыг анзааран жолоочоос асуувал Малайзын ерөнхий сайд Махатхирын дэвшүүлсэн 2020 оны Малайзын хөгжлийн зорилтыг илтгэж байгаа гэж хариулав.

Малайз нь Английн колони байж байгаад 1957 онд тусгаар тогтнолоо олжээ. Анхандаа Сингапур нэгдмэл байсан боловч 1965 онд салан тусгаарласан байна. Малайз нь холбооны улс бөгөөд 9 султанат болон 4 муж, нийт 13 өөртөө засах штатаас бүрддэг байна. Малайзын хүн ам 1991 оны байдлаар 18 сая байгаагийн дийлэнх хэсэг—60 хувь орчмыг малайчууд, 40 хувь орчмыг хятад (30 хувь), Энэтхэгчүүд (10 хувь) эзэлдэг байна. Малайчуудын ихэнх нь төрийн шашин болох сүннит чиглэлийн исламыг шүтдэг.

Малайзын есөн султан нэг нэгээрээ ээлжлэн үндсэн хуульт хаант улсын дээд эрхийг барьдаг байна. Тэдний хамгийн залуу болох Келантан штатын султан 42 настай Исмаил Петра машинд нэн хорхойтой нэгэн ажээ. Энэхүү султан аль хэдийн гадаадаас 21 автомашин оруулж ирсэн боловч 1992 он гарсаар 22 дахь машинаа Лондоноос авчирсныг тэндхийн сонинд шагшин бичиж байв. Энэ удаад султан гаалийн албанд машин оруулж ирсний татвар төлөхөөс татгалзсан учир Келантан штатын захиргаа болон холбооны Засгийн газрын хооронд «бяцхан» зөрчил үүссэн байна.

Азийн хөгжлийн банкны тооцоолсноор 1992 онд Азийн эдийн засгийн түргэн хөгжлийн тэргүүн эгнээнд Малайз, араас нь Тайланд, Хятад дагах ажээ. Азийн орнуудын хөгжлийн дундаж хурдац 6,5 хувь байхаас Малайзынх 8,5 хувь байх төлөвтэй. Үүнийг бидэнтэй уулзсан Малайзын эдийн засгийн судалгааны институтийн судлаачид ч ярьж байв. Тус институт Малайзын 1991-2000 оны удаан хугацааны хөгжлийн стратегийг боловсруулснаас гадна жил бүр эдийн засгийн өсөлтийн төлөвийг тодорхойлдог байна.

1981 онд засгийн эрхэнд гарсан ерөнхий сайд Махатхир «шударга, үр ашигтай, найдвартай байх» гэсэн лоозонг мөрдлөг болгон ажиллажээ. Түүний Засгийн газрын гол зорилго Малайзыг аж үйлдвэржсэн орон болгоход оршиж байна. Үүнийг хэрэгжүүлэх зорилгоор хэд хэдэн шинэ үзэл санааг дэвшүүлсэн байна. Үүний нэг нь «Дорно зүг хар» буюу Япон, Өмнөд Солонгосын туршлагаас суралцъя гэсэн үзэл санаа ажээ. Ерөнхий сайд Махатхир Малайзыг өөр нэг Япон юм уу, Өмнөд Солонгос болгох гэсэн бус, харин аж үйлдвэржсэн орон болсон тэдний туршлагыг хэрэглэхийг хичээжээ. Нэг үгээр хэлбэл, малайзынхныг тэдэн шиг ажилсаг, сахилга баттай, бүтээлч болгохыг чармайсан байна. Энэ зорилгодоо ч түүний Засгийн газар тодорхой амжилтанд хүрчээ. Тухайлбал, электроник бүтээгдэхүүн Малайзын нийт экспортын 18 хувь орчмыг эзлэх болж ач холбогдлоороо хоёрт орох болсон байна. Малайзын жилийн экспортын өртөг 34,7 тэрбум ам. Долларт хүрч АСЕАН-ы орнууд дотор Индонез, Тайландын аль алинаас давж, Сингапурын дараа орох болсон байна.

4 дүгээр сарын 13—16.

Куала-Лумпураас 50 орчим минут нисэж Сингапурт хүрэв. 620 км² нутагтай энэхүү хот улс 1965 онд Малайзын холбооноос гарч, тусгаар улс болсон юм. Тэр үед хүн амынх нь 78 хувь хятад, 14 хувь малай, 8 хувь энэтхэгчүүд байлаа. Тиймээс чихэвчлэн малайчууд дийлэнх нь болох хөрш орнуудын дунд Сингапур хятад хүн ам голлосноороо тод ялгарч байв.

Бидний зочилсон Зүүн өмнөд Ази судлалын институтийн захирал Санду уг хүрээлэн анх байгуулагдсан түүхийг ярьж өгсөн юм. Дөнгөж тусгаар тогтносон Сингапурт хөрш орнуудынх нь талаарх мэдлэг

хомс, мэдээлэл дутагдаж байв. Иймээс Сингапурын Засгийн газар ийм институт байгуулж, захирлаар нь гаднын хүн байхаар бодож, америк хүнийг урьсан байна. Дараа нь австрали эрдэмтэн, мөн гурав дахь захирал ч америк хүн байжээ. Эцэст нь Сандуг захирлаар урьсан байна. Сандуг уг Институт нь олон орны эрдэмтдэд нээлттэй, Сингапурт байрласан олон улсын судалгааны газар байх санал дэвшүүлж, түүнийгээ хамгаалж чадсан байна. Мөн уг институтийг Сингапурын Засгийн газраас санхүүжихээр болгожээ. Засгийн газар барилга, номын сангийн байр, 17 гүйцэтгэх ажилтны орон тоог баталж өгчээ. Зөвхөн энэ 1992 оны санхүүгийн жилд Сингапурын парламент уг институтэд 7 сая сингапур долларын төсөв баталж өгсөн гэж захирал танилцуулав.

Тус институт дэлхийн бүх орны эрдэмтдэд нээлттэй. Энд Зүүн өмнөд Азийг судлахаар олон арван эрдэмтэн жил бүр ирдэг байна. Тухайлбал, Австралийн тал өөрийн эрдэмтдийг уг институтэд судалгаа хийхэд нь зориулж жил бүр 35 мян. ам. доллар зарцуулдаг байна. Институт гурван үндсэн зорилго дэвшүүлжээ. Нэгд, Зүүн өмнөд Азийн орныхныг бие биенийхээ тухай улам сайн мэддэг болгох, үүний тулд бүс нутгийн судалгааг өргөжүүлэх, хоёрт, гадаад ертөнц Зүүн өмнөд Азийн тухай илүү мэдээлэлтэй болоход бүх талын дэмжлэг үзүүлэх, гуравт, Зүүн өмнөд Азийн талаарх мэргэжилтнийг тэдгээр оронд өөрсдөд нь бэлтгэж өгөх, эдгээр болно.

Гуравхан сая хүнтэй энэхүү хот улсын нэг хүнд ногдох орлого 13600 ам. долларт хүрээд байна. Энэ нь Сингапурын ерөнхий сайдын албыг 30 шахам жил хашсан Ли Куан Ю-гийн нэртэй шууд холбоотой. Тэрээр 3-хан арван жилийн хооронд Сингапурыг 3600 үндэстэн дамнасан корпорац байрласан, тив дэлхийн хот болгож чадсан байна. Хүн амынх нь амьдралын төвшин Азид Японы дараа хоёрдугаарт орохоор болжээ. Хүн амын 80 хувь нь хувийн байртай гэсэн тооцоо бий. Ли Куан Ю-гийн тухай «Ли байгаагүй бол юу болох байсан бол оо?» Хэмээх нэгэн номыг номын дэлгүүрээс худалдан авсан билээ. 1990 онд тэрээр ерөнхий сайдын суудлаа Го Чок Тонд шилжүүлж өгсөн байна.

Өнөөгийн ерөнхий сайд Го Чок Тонгийн дэмжлэгтэй байгуулагдсан Төрийн бодлого боловсруулах институтэд бид зочилсон юм. АНУ-д сууж байсан элчин сайд Томми Ко уг институтийн захирал юм байна. Тэдний ярианаас үзвэл өнгөрсөн 25 жилд Сингапур үндэстэн дамнасан корпорацудад «үйлчлэх» хэлбэрээр өнөөгийн хөгжлийн төвшинд хүрчээ. Тэгвэл дараагийн 25 жилд Сингапур дотоодынхоо нөөцийг нээх, иргэдийнхээ аж ахуй эрхлэн хөтлөх авьяасыг хөгжүүлэх замаар хөгжлийн шинэ шатанд гарах итгэл төгс байна.

4 дүгээр сарын 17-21.

Индонезийн нийслэл Жакарт хот биднийг бороогоор угтаж, бороотой үдсэн гэж хэлэхэд болно. Энд хийсэн хэд хэдэн уулзалтаас сэтгэлд хамгийн унацтай үлдсэн нь олон жил Индонезийн Сангийн яамны албыг хашсан профессор Мохаммад Садлитай хийсэн уулзалт болно. Тэрээр эдийн засгийг тогтворжуулахын тулд 1983, 1986 онд Индонезийн мөнгөн тэмдэгт-рупийгийн ханшийг хоёр дахин хүчтэй бууруулах болсныг ярих. Үүний дүнд америк доллартай харьцах рупийгийн ханшийг тогтворжуулж авчээ. Индонез олон улсын байгууллага, донор орны тусламжид их шүтдэг юм байна. Үндсэндээ гаднын тусламж, зээллэгийн 1/3-ийг АНУ, 1/3-ийг Япон, үлдэх 1/3-ийг олон улсын санхүүгийн байгууллагууд олгодог ажээ. Одоо ч жилдээ 4—5 тэрбум ам. долларын тусламж, зээллэг авдаг хэвээр гэж тайлбарлав. Улс орны хөгжлийн стратегийг 25 жилээр тодорхойлдог юм байна. Одоо өмнөх

25 жилийн дүнг гаргаад дараагийн 25 жилийн хөгжлийн зорилтыг дэвшүүлж байгаа цаг ажээ. 25 жил дотроо эдийн засгаа 5 жилээр хуваан төлөвлөдөг зарчимтайг профессор Садли ярилаа.

Ийнхүү Зүүн өмнөд Азийн таван орноор аялсан 3 долоо хоногийн аялал маань төгссөн билээ. Үүний дараа урьд нь төсөөлөхөд хэцүү, их л холын юм шиг бодогддог байсан эдгээр орон сэтгэлд нэг л дотно ойрын болсныг тэмдэглэхэд таатай байна.

1992. 06. 22.